




## ЭРТ ҮЕИЙН СЭРГЭН БОСГОЛТЫН ХӨТӨЛБӨР



### Зудад өртсөн хүн амын тоо:

420,000 хүн зудад нэрвэгдээд байгаа нь нийт хүн амын 15 хувь бөгөөд тэдгээрээс 159,350 нь хүүхдүүд байна (НҮБ-ын Хүн амын сан)

### ХХААХҮЯ-ны мэдээгээр хорогдсон малын тоо:

- 2010 оны 1 сарын 5-ны байдлаар 45,831 (зудын хохирлыг албан ёсоор тоолж эхэлсэн)
- 2010 оны 2 сарын 1-ний байдлаар 175,6711
- 2010 оны 3 сарын 1-ний байдлаар 3,010,235
- 2010 оны 3 сарын 13-ны байдлаар 3,766,000
- 2010 оны 3 сарын 30-ны байдлаар 5,523,663

# ЭРТ ҮЕИЙН СЭРГЭН БОСГОЛТ

## ЗУД ( 2009-2010 )

2010 оны өвөл, хавар малчдад хүндээр тусч олон хоногоор үргэлжлэн орсон цасны улмаас Монгол орны нийт газар нутагт цасан бүрхэвч тогтож, цасны зузаан нийт нутгийн 60 хувьд 20-40 см-т хүрээд байгаа билээ. Хэдийгээр монголчууд өвлийн хахир хатууг ажрахгүй давдаг боловч энэ жилийн хувьд онцгой хүйтэрч, хүйтний эрч -50 хэм хүрч мал бэлчээх боломжгүй болсон зуд тохиолоо. Зуд таваас арван жилд нэг тохиодог байсан бол сүүлийн арван жилд дөрвөн удаа зуд болсон бөгөөд ойрын жилүүдэд ч давтагдах төлөвтэй байна.

2009-2010 оны зудын улмаас 3-р сарын дунд гэхэд 3,7 сая мал хорогдоод байгаа нөхцөлд НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлж байна. Цаг агаарын одоогийн нөхцөл байдал үргэлжилвэл зунтай золготол 6 сая орчим мал хорогдох төлөвтэй байгаа юм. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс ОБЕГ, Худалдаа, аж үйлдвэрийн үндэсний танхим, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллаж, орон нутагт зудын уршгийг арилгах талаар тусламж дэмжлэг үзүүлж байна. Энэ үйл ажиллагаагаар гол нь ядуурлын түвшнээс доогуур амьжиргаатай иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, өндөр настан болон нийгмийн бусад эмзэг бүлгүүдэд хүрч ажиллахыг зорьж байгаа юм.

### Гамшгийн эрт үеийн сэргэн босголтын стратеги гэж юу вэ?

НҮБХХ-ийн зүгээс зудын эрт үеийн сэргэн босголтын стратегийн хүрээнд дараах зорилтуудыг тодорхойлсон. Үүнд:

- А.Малын сэг зэмийг устгах
- Б.Амьжиргааны шинэ эх үүсвэр бий болгох чадавхийг бэхжүүлэх
- В.Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах чадавхыг дээшлүүлэх

**Эрт үеийн сэргэн босголт** – хүмүүнлэгийн үйл ажиллагааны хүрээнд эхний шатанд хохирлыг даван туулах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хэлнэ. Үүнд нийгмийн суурь үйлчилгээний хэвийн ажиллагааг хангуулах, амьжиргаа, засаглал, аюулгүй байдал, хүрээлэн буй орчин, нийгмийн үзүүлэлтүүдийг сэргээх, тэдгээрийн дотор мөн дайжиж нүүсэн хүн амыг нутагт нь суурьшуулах үйл ажиллагаа багтана. Энэхүү ажлын хүрээнд хүн амын аюулгүй байдал баталгаажиж, уул хямрал үүсэхэд нөлөөлсөн суурь хүчин зүйлсийг бууруулахад түлхүү анхаардаг. (Эх үүсвэр: НҮБХХ)



Эх үүсвэр: Б. Оргил, UBS TB


**Зуд** гэж өвөл, хаврын улирлын үргэлжилсэн урт хугацаанд мал сүрээ бэлчээр, усаар нэн гачигдаж турж зутран, улмаар үй олноор хорогдох нөхцөл бүрдэхийг хэлнэ (Ган, зуд, агаар мандлын гаралтай бусад гамшигт үзэгдлийн цагийн байдалд үнэлгээ хийх журмын төсөл, ОБЕГ, 2008)

### Малын сэг зэмийг устгах

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр цаг агаарын онц аюултай нөхцөл байдлын улмаас амьжиргаагүй болсон малчдыг орлого олох боломжоор хангахын сацуу тэдгээрт учирч болзошгүй эрүүл мэндийн эрсдлийг бууруулахын тулд зуданд хорогдсон малын сэг зэмийг зайлуулж устгахад чиглэгдсэн “Хөдөлвөл хөлс” тусгай хөтөлбөрийг Онцгой байдлын ерөнхий газартай хамтран хэрэгжүүлж байна. Тэрчлэн энэ хөтөлбөр олон тооны малаа алдсан малчдад сэтгэл санааны дэм болох юм. Төслийн хүрээнд 2 сая орчим малын сэг зэмийг зайлуулж устгах юм. ОБЕГ сэг устгаж арилгах ажлыг зохион байгуулахын сацуу малчдыг тусгай хувцас, багаж хэрэгсэл, ариутгалын бодисоор хангана.

Малчин өрхүүдийн 80% нь 200-аас доош толгой малтай бөгөөд цаг агаарын эрсдэлд туйлын эмзэг юм. Эдгээр өрхүүд энэ жилийн зуднаар малынхаа тэн хагасыг алдсан өрхүүдийн олонхи нь болж

Зуд, гамшигийн байдал бүхий газрын зураг



Эх үүсвэр: НҮБ-ын Хүүхдийн Сан

# НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

байгаа бөгөөд “Хөдөлвөл хөлс” хөтөлбөр нь эдгээр өрхөд орлого олох боломжийг нээж гэр бүлээ тэжээх, эм тариа авах, хүүхдийнхээ боловсролд зарцуулах, зээлээ төлөхөд нь ихээхэн тус нэмэр болох юм.

**Санхүүжилт:** 1,8 сая ам. доллар  
Зудад нэрвэгдсэн бусад аймаг, сумыг хамрахад нэмэлт хөрөнгө шаардлагатай байна.

**Зорилтот бүлэг:** НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр ОБЕГ болон орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллаж, 20,000 малчныг хамрахаар төлөвлөж байна. Хөтөлбөрийг олон нийтийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлэх ба 200-аас доош тооны малтай өрх, өрх толгойлсон эмэгтэйчүүд, бусад эмзэг бүлгийн иргэдийг түлхүү хамруулна.

**Байршил:** Зудадихээхэн нэрвэгдсэн Өвөрхангай, Дундговь, Ховд гурван аймаг, нийт 51 сум

**Хугацаа:** 2010 оны 3 сарын 1-ээс 6 сарын 1 хүртэл нийт гурван сар

**Хөдөлвөл хөлс хөтөлбөр нь хүмүүнлэгийн тусламжийн байгууллагууд хүн амын хамгийн эмзэг хэсгийнхнийг зам засах, нуранги цэвэрлэж зөөх, дэд бүтцийг сэргээн босгох зэрэг олон нийтийн ажилд түр ажлын байраар хангах богино хугацааны хөтөлбөр байдаг. Энэ нь шинэхэн аргачлал боловч хүнсний аюулгүй байдал алдагдсан, гамшигт нэрвэгдсэн нөхцөлд түгээмэл хэрэглэгдэж байна. ([www.reliefweb.int](http://www.reliefweb.int)).**

## Орлогын шинэ эх үүсвэр бий болгох чадавхийг бэхжүүлэх

Зудад өртсөн хүн амыг мал аж ахуйгаас өөр орлогын тогтвортой эх үүсвэртэй болгох зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн шугамаар хэрэгжиж байгаа төслүүд болон төр, хувийн хэвшлийн санаачилгын үйл ажиллагааг шинэчлэн төлөвлөх замаар зах зээлийн эрэлтэд чиглэсэн мэргэжлийн сургалт, бизнесийн сургалт зохион байгуулж, шинэ бизнес эхлэхэд зориулан менежментийн дэмжлэг үзүүлж, бага оврын тоног төхөөрөмжөөр хангана.

Зудын давтамж нэмэгдэж байгаа нөхцөлд малчдыг уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшгаас хамаарал багатай, мөн байгаль орчинд хор нөлөөгүй эдийн засгийн салбарт ажиллахад дэмжлэг үзүүлэх шаардлага бий болоод байна. Мэргэжил олгох сургалт, арга зүйн тусламж нь мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах, нэмүү өртөг бий болгох үйлдвэрлэлийн арга ажиллагаанд сургахад чиглэгдэнэ. Үүнд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болон шинэ ажиллах хүчийг шингээх зах зээлийн багтаамж, эрэлт, малчдын бүлгүүдийн чадвар чадавхийг харгалзана.

**Санхүүжилт:** 1,4 сая ам. доллар  
**Зорилтот бүлэг:** Зудад өртсөн малчид, малчдын бүлэг, хоршоод  
**Байршил:** Урьдчилан тодорхойлсноор Увс, Өвөрхангай, Дундговь, Ховд аймаг  
**Хугацаа:** 2010 оны 4 сараас 2011 оны 4 сар хүртэл нэг жил

## Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах чадавхийг дээшлүүлэх

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс ОБЕГ дээр нэгж байгуулах замаар үндэсний болон орон нутгийн түвшинд гамшгийн үеийн үйл ажиллагааг зохицуулахад дэмжлэг үзүүлж байна. Эрт үеийн сэргэн босголтын ажлыг зохицуулах баг дараах хүрээг хамарч ажиллана:

(а) Эрт үеийн сэргэн босголтын ажил, түүний дотор малын сэг зэмийг устгах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах чиглэлээр төрийн байгууллага болон хандивлагч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах механизм бий болгох;

(б) Төрийн болон хандивлагч байгууллагуудтай харилцаа холбоогоо сайжруулж, улс орны хэмжээний нөхцөл байдал, тусламжийн хэрэгцээний талаар цаг тухайд нь мэдээлэх, тусламж хуваарилалт ашиглалтын ил тод байдлыг хангах;

(в) Мэдээллийн технологи ашиглан гамшгийн цар хүрээ, хохирлын хэмжээ, хүлээн авсан тусламжийн баримтжуулалт, хохирлыг эрт даван туулах ажиллагаанд дутуу, шаардлагатай зүйлсийн талаар зурагласан мэдээллээр хангах.

Баг нь гамшгийн үеийн үйл ажиллагааны зохицуулалтын олон улсын мэргэжилтэн болон үндэсний дөрвөн ажилтан, нийт таван гишүүнээс бүрдэнэ.

**Санхүүжилт:** 100,000 ам. доллар  
**Үр шимийг хүртээгч:** Онцгой байдлын ерөнхий газар  
**Хугацаа:** 2010 оны 4 сарын 1-ээс 10 сарын 1 хүртэл, зургаан сар



Эх үүсвэр: НҮБХХ-ийн Цөлжилтийг бууруулах газрын тогтвортой менежмент төсөл

Хаяг:  
Ориент Плаза,  
Г. Чагдаржавын гудамж 9,  
1-р хороо, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар - 14210

Утас: +976-11-327585  
Факс: +976-11-326221  
Цахим хуудас: [www.undp.mn](http://www.undp.mn)  
Цахим шуудан: [registry.mn@undp.mn](mailto:registry.mn@undp.mn)